



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Эрчим хүчний яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 576,793,147.98 (таван зуун далан зургаан сая долоон зуун ерэн гурван мянга нэг зуун дөчин долоон төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхэд төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан 49.2 (дөчин есөн тэрбум хоёр зуун сая) тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.3. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 хороонд байрлах, 5,992 м.кв талбай бүхий, 191.75 (нэг зуун ерэн нэгэн сая долоон зуун тавин мянга) сая төгрөгийн үнэлгээ бүхий газраас 2021 онд "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-д шилжүүлсэн, 1,026 м.кв газрын үнэлгээг хасаж санхүүгийн тайланд залруулга хийх, эрх бүхий этгээдэд хандан шийдвэрлүүлэх;

2.4. Эрчим хүчний яамны нэр дээр бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байршилтай, Амины орон сууцны зориулалтаар авсан газрыг зориулалтын дагуу ашиглах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт санал боловсруулан хүргүүлэх;

2.5.Эрчим хүчний яамны нэр дээр бүртгэлтэй, 5 ширхэг, 1,054,344 м.кв газар эзэмших/ашиглах эрхийг Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлж санхүүгийн тайланд тусгах;

2.6.“Скайтел, Мобиком компаниудтай байгуулсан үүрэн телефоны антен түрээслэх гэрээг шинэчлэн байгуулах, түрээсийн 2022 оны 4 дүгээр улирлын төлбөр 1,056.0 (нэг сая тавин зургаа) мянган төгрөгийг нэхэмжлэн авч орлогыг Улсын төсөвт төвлөрүүлэх;

2.7.Бусад байгууллагуудад шилжүүлсэн газар, тээврийн хэрэгслийг Авто тээврийн үндэсний төв, төрийн мэдээлэл солилцооны ХҮР системийн мэдээлэлтэй тулган шаардлагатай залруулга хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.8.Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн программ хангамжид шаардлагатай хөгжүүлэлт, нэмэлт өөрчлөлтийг хийлгэх хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах;

2.9.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, барилга, байгууламжуудад хувийн хэргийн хөтлөлтийг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-т заасны дагуу хөтлөх;

2.10.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны
өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ,
АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ,
ДУТАГДЛЫГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр дуусаагүй барилга данснаас хөрөнгө хассан.	222,080,515.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг мөрдөж ажиллах.
2	Урсгал төсөв болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт.	34,943,190.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
3	Барилга байгууламжийн хувийн хэргийн хөтлөлт хийгдээгүй.	-	Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь хэсэгт заасныг мөрдөж ажиллах.
4	Маргаантай хөрөнгийн талаар /Барилга шилжүүлэн авсан боловч нийтийн эзэмшлийн хөрөнгийг салгаж шилжүүлсэн/	294,895,442.98	“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-иас маргаантай хөрөнгийг шилжүүлэн авах
5	Төрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэн, олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй.	1,056,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
6	Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоос зөрүүтэй дүнгээр үндсэн хөрөнгөд орлого авсан.	23,818,000.00	Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоол болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
7	Төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшиж буй газрын хэмжээ буурсан боловч санхүүгийн тайланд бүртгэсэн дүнд өөрчлөлт оруулаагүй.	1,026 м.кв	Газрын буурсан талбайн хэмжээ дүнгээр санхүүгийн тайланд өөрчлөлт оруулах.

8	Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн зориулалттай газрын балансаас балансад шилжүүлсэн боловч газрын гэрчилгээний эзэмшигч зөрүүтэй.	16,796 м.кв	Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
9	4 ширхэг газрын гэрчилгээг баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд үнэлж тусгаагүй.	634,344 м.кв	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН		576,793,147.98	төгрөг (Таван зуун далан зургаан сая долоон зуун ерэн гурван мянга нэг зуун дөчин долоон төгрөг ерэн найман мөнгө)
		652,166 м.кв	(Зургаан зуун тавин хоёр мянга нэг зуун жаран зургаан) талбай бүхий газар

-----oOo-----